

“БУРХАН ҮХСЭН” ХЭМЭЭХ ФРИДРИХ НИЦШЕГИЙН ҮЗЛИЙГ ТАЙЛБАРЛАХ НЬ

О.Мөнгөнсор (Магистрант)

М.Отгонбаяр (Доктор Ph.D)

Философи, шашин судлалын тэнхим, МУИС

Түлхүүр үгс: Бурхан үхсэн, бурханыг хөнөөсөн алуурчин, сюпер хүн хэрхэн болох

Товч утга: Ф. Ницше “Бурхан үхсэн” хэмээх хэллэгээрээ ихэд алдартай. Хүмүүс хорвоогийн хамаг муу муухайг хүн төрөлхтөнөөс хайлгүйгээр, өөрсдийгөө хаацайлан бурууг хэн нэгэн рүү нялзаахдаа энэхүү үгийг их иш татдаг. Тэрээр Христийн шашныг шүүмжлэхдээ хурц ширүүн үг хэллэг, ухаалаг үндэслэгээ, ёжлол егөөдлийг хэрэглэсэн. Христийн шашныг шүүмжилсэн Фридрих Ницшегийн үзэл санааг ойлгохын тулд түүний “Заратустра ингээж хэлсэн” зохиол дахь Бурхан үхсэн, бурхад үхсэн, хөгшин бурхан үхсэн, бурхад үхэхдээ янз бүрээр үхдэг гэсэн хэллэгүүдийн утга учрыг тодруулах шаардлага нэн түрүүнд тулгарч байна. Бурханы үхлийн тухай Ницшегийн тунхаглал Христийн шашинтай хэрхэн холбогдох вэ? Шинэ гэрээнд Есүс Христийн баптисмийн үеийн талаар (Матай 3:16-17) “Есүс баптисм хүртээд, голын уснаас тэр даруй гарах үед тэнгэр заагдаж, Бурханы Сүнс тагтаа лугаа адил бууж, Түүн дээр ирэхийг тэр харав. Тэнгэрээс -Энэ бол Миний хайрт Хүү. Түүнд Миний таалал оршдог гэх дуу гарлаа” гэж бичигдсэн байдаг. Христийн шашинд Trinity буюу Гурвал, Holy Trinity Ариун гурвал нь Бурхан, Есүс Христ, Ариун сүнсийг хэлэх ба гурвуулаа өөр өөр боловч нэгдмэл нэгэн зорилготой гэдэг утгатай юм. Фридрих Ницше хөгшин бурхан, Бурхан, бурхад гэдгээр ямар бурхныг илэрхийлсэн байж болох вэ?

Фридрих Ницше “Ёс суртахууны үүсэл гарвал” номондоо амьдарч буй үеийнхэн болон тэдний өвөг дээдсийн хоорондын харилцааны тухайд орчин үеийнхэн ойлгоход түвөгтэй зүйлийн талаар дахин шинээр авч үзэж байгаагаар бичжээ. Энэ нь “өвөг дээдэстээ өртэйгээ мэдрэх мэдрэмжийн”¹ тухай бөгөөд эрт цагт овог аймгийн үр удам өмнөх өвөг дээдэсдээ, ялангуяа тэрхүү овог аймгийг үүсгэн байгуулсан эцэг өвгөддөө өртэйгээ хүлээн зөвшөөрдөг хэмээжээ. Овог аймаг нь зөвхөн өвөг дээдсийнхээ хийсэн золиослол, ололт амжилтын хүчинд оршин тогтнож байгаа бөгөөд үр удам нь тэдэнд мөн адил амжилт ба золиослолоор дамжуулан өрөө төлөх гэсэн итгэл үнэмшилтэй байх бөгөөд өвөг дээдсээсээ айх айдас, тэдэнд өртэйгөө ухамсарлах нь овог аймгийн хүч чадал бэхжихэд нөлөөлж, овог аймаг илүү ялгуусан, чөлөөт, хүндэтгэм, болгоомж төрүүлсэн болдог гэжээ. Ницше хүмүүс

өвөг дээдэстээ золиослолууд, баяр наадмууд, сүм дуганууд, хүндэтгэлийн илэрхийллүүдээр дамжуулан, хамгийн чухал нь өвөг дээдсийнхээ бүтээл болох бүхий л ёс заншил, хөшөө дурсгалууд, зарлиг тушаалуудад дуулгавартай байх замаар өрөө эргүүлэн төлдөг гэж үзсэн.

Ницшегийн хувьд догшин ба нигүүлсэнгүй гэсэн хоёр төрлийн бурхан байдаг. “Урьд нэгэн цагт эзэн тэнгэр нь ард түмнийг, ард түмний хүч чадлыг, ард түмний сэтгэл дэхь түрэмгий, эзэрхлийн хүслэн болсон бүхнийг илэрхийлдэг байлаа – одоо тэр зөвхөн ач тусын эзэн тэнгэр төдий боллоо... Үнэндээ тэнгэр бурхдад сонголтын өөр хувилбар байхгүй: эсвэл тэд эзэрхэх хүсэл зориг мөн, тэр тохиолдолд тэд үндэсний тэнгэр бурхад болж байдаг, - эсвэл тэд эзэрхэг хүчний мөхөсдөл мөн – тэр тохиолдолд тэд зайлшгүй эрхээр нигүүлсэнгүй болдог”² ба догшин эзэн тэнгэр нь нигүүлсэнгүй эзэн тэнгэрийн адил хэрэгтэй хэмээн үзжээ.

¹ Friedrich Nietzsche - On the Genealogy of Morals. Translated by Ian Johnston of Malaspina University-College. Nanaimo. BC. Canada. page 45.

² Фридрих Ницше. Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу Эллин ёс ба гутрангуй үзэл. Христэд тэрслэгч. орч. О.Чимэг. УБ., 2012 он. 193 дахь тал.

Ницше “Зугаатай шинжлэх ухаан” болон “Заратустра ингэж хэлсэн” номондоо Бурханы үхлийн тухай бичсэн байдаг. Зохиолын гол дүр Заратустра Ницшегийн “чөлөөлөгдсөн хүн” хэмээн дүрсэлсэн нэгэн хүнтэй тааралдан түүнтэй ярилцаад ойд байх агуйн гэртээ урьдаг ба түүнийг “ертөнц даяараа шүтэж байсан хөгшин Бурхан нэгэнт үхсэн тухай” ойд амьдардаг ариун гэгээн хүнд хэлэхээр явж байгааг мэджээ. Тэрхүү уйтгар гунигт автсан хөгшин өөрийгөө “хуучин Бурханд сүүлчийн мөч хүртэл нь хүчин зүтгэсэн, эзэнгүй, чөлөөлөгдсөн хүн, сүүлчийн хутагт хамба” гэдэг. Заратустра түүнээс “Чи эцсээ хүртэл түүнд зүтгэсэн, түүнийг яаж үхсэнийг мэдэх үү? Өрөвдөх сэтгэл нь түүнийг багалзуурдсан гэдэг үнэн үү? Тэрээр хүн загалмайд дүүжлүүлснийг хараад тэсээгүй, тиймээс хүнийг хайрлах хайр нь түүнд там, эцэстээ үхэл нь болсон гэдэг үнэн үү? хэмээн асуугаад “Түүнийг орхи, тэр үхсэн. ...Бурхад үхэхдээ янз бүрээр л үхдэг”³ гэж хэлдэг. “Зугаатай шинжлэх ухаан” номонд нэгэн галзуу солиотой хүн өдрийн цагаар арилжааны захаар дэнлүү барин Бурханыг хайж явдаг бөгөөд “Бурхан үхсэн. Бурхан үхсэн хэвээр үлдлээ. Бид түүнийг хөнөөчихсэн” гэдэг. Фридрих Ницше болон түүний зохиолын гол дүр Заратустра Бурханыг хөнөөгөөгүй бөгөөд “Заратустра ингэж хэлсэн” зохиолд Бурханыг хөнөөсөн алуурчны тухай бий.

Заратустра ингэж хэлсэн зохиолын төгсгөл хэсэгт Заратустра дээдийн хүмүүс хэмээн нэрлэгдэх 1) баруун гарын хаан, 2) зүүн гарын хаан, 3) хөгшин шидтэн, 4) хутагт хамба, 5) сайн дурын гуйлгачин, 6) сүүдэр, 7) ичих нүүртэй хүн, 8) гунигтай зөнч, 9) илжиг, 10) хамгийн муухай хүнтэй агуйдаа уулздаг. Энэхүү уулзалтыг эхэлсний дараахан нь “Энэ бол ном сударт <<Нууц үдэш>> хэмээсэн тэрхүү удаан үргэлжилсэн ярианы эхлэл байлаа” хэмээн дүрсэлжээ. Заратустрагийн агуйд очсон эдгээр арван зочид дээр Заратустраг мөн түүний хайртай амьтад болох могой болон бүргэдийг нэмснээр арван гурвуулаа болж буй. Еврейчүүдийн тэмдэглэдэг Дээгүүр өнгөрөх баярын утга учир бол тэд Египетийн боолчлолоос гарахын өмнө Египет буюу Фараоны хүн ардад олон гай гамшгууд тохиолдсоны хамгийн сүүлийнх

нь буюу бүх өрх айл, гэр бүл бүрийн ууган хүү, мал сүргийн бүх анхны төл бүгд үхдэг тэрхүү гамшгийг хурганы цусыг гэрийнхээ хатавч тогтонд түрхсэнээр бүгд эсэн мэнд үлдсэн түүхийг эргэн дурсан санахын тулд юм. Энэхүү баяраар тусгай зоог иддэг ба Шинэ гэрээнд Исгээгүй талхны баяр хэмээн дүрсэлжээ. Шинэ гэрээнд Есүс Христ өөрийн арван хоёр шавь нартайгаа идсэн зоогийг “Сүүлчийн оройн зоог” хэмээн нэрлэдэг бөгөөд үүний дараахан нь тэрээр баривчлагддаг. Тэд арван гурвуулаа байжээ.

Шинэ гэрээний “Иохан” номын 13:21-27-д “21 Есүс эдгээрийг хэлээд, сүнс нь шаналж эхлэн, гэрчилж -Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Та нарын нэг Намайг барьж өгнө гэлээ. 22 Түүний хэний тухай ярьж буйг мэдэх гэж гайхшран, шавь нар нь бие бие уруугаа харж эхлэв. 23 Түүний шавь нарын нэг болох Есүсийн хайрласан хүн Есүсийн цээжийг налаад сууж байлаа. 24 Тэгтэл Симон Петр түүн уруу дохиж, -Түүний хэний тухай хэлж байгааг бидэнд хэлээч гэв. 25 Тэр Есүсийн цээжийг налсан хэвээр -Эзэн, тэр хэн юм бэ? гэсэнд 26 Есүс -Энэ талхыг Би дүрээд хэнд өгнө, тэр хүн нь мөн гэж айлдаад, талхны хэлтэрхийг дүрж [аваад] Искаротын Симоны хүү Иудаг өгчээ. 27 Дараа нь түүнд Сатан шүглэв. Тэгтэл Есүс Иудаг -Чи хийх гэж байгаа юмаа түргэн хий гэлээ”. Заратустрагаар ойд тааралдан ярилцдаг “хамгийн муухай хүн” (хүнтэй адил, хүн гэж дүрсэлшгүй юм): “<<Заратустра, Заратустра! Миний оньсогыг таа! Хэл, хэлээч! Гэрчээс өшөө авах гэж юу вэ? ... Би хэн бэ, хэлээдэх!>>. Заратустра: <<Би чамайг сайн мэдэж байна. Чи Бурхныг алсан! Чи өөрийгөө харсан хүнийг – чамайг, хамгийн муухай хүнийг нэвт харсан хүнийг тэвчээгүй. Чи тэр гэрчээс өшөө авсан!>> ... Хамгийн муухай хүн: Чи таасан. Бурхныг алсан хүнд - Бурхныг алсан алуурчинд ямар байхыг чи таасан, би мэдэж байна. ... Түүнийг хөнөөсөн хүнд ямар байхыг чи таасан”⁴. Христийн үхэлд хэн буруутай вэ? Түүнийг боломж л олдвол хөнөөхийг хүсэж байсан фарисайчууд, цовдлох тушаал өгсөн Ромын захирагч Пилат, Есүсээс урвасан түүний арван хоёр шавийн нэг Иудас, эсвэл түүнийг цовдолсон бас жадалсан цэргүүд үү?

³ Фридрих Ницше. Заратустра ингэж хэлсэн. орч. Б.Батаа. УБ., 2014 он. 349-351 дэх тал.

⁴ Фридрих Ницше. Заратустра ингэж хэлсэн. орч. Б.Батаа. УБ., 2014 он. 355-356 дахь тал.

Заратустра зохиолыг төгсгөл хэсэгт олон хүн Заратустрагийн ууланд агуйд нь очсон байдаг ба тэд өөрсөдөө дахин бурхан бий болгосон байдаг (бурхан-илжиг) тухай дүрсэлжээ. Заратустра: "...хөгшин хутагт хамба чи Бурханд мөргөх мэт ийм дүртэй илжгэнд мөргөж байгаа өөртэйгөө яаж эвлэрч чадав? Хутагт хүн хариуд нь "Аяа, Заратустра намайг өршөө, гэхдээ Бурханы асуудалд би чамаас илүү гэгээрсэн! Энэ нь дээр байна. Ямар ч дүргүй зүйлд мөргөснөөс Бурхны ийм дүрд мөргөсөн нь дээр" гэжээ. Заратустра хэрэн бидэгч сүүдэрт хандан "Чи ч гэсэн өөрийгөө чөлөөтэй сэтгэл гэж нэрлэх үү? тэгээд бас энд ийм шүтээнд мөргөж, хуурамч зүйл хийж байна уу? Хэрэн бидэгч сүүдэр хариуд нь <<Тийм ээ чиний зөв, их л булай хэрэг, гэвч яалтай билээ! Аяа, Заратустра чи юу ч гэж хэлсэн хуучин бурхан амьд хэвээрээ байна. Бүх зүйлд хамгийн муухай хүн буруутай: тэр түүнийг дахиад амилуулчихсан. Хэдийгээр тэр нэгэн цагт түүнийг хөнөөсөн гэж ярьдаг ч – бурхдын үхэл үргэлж мухар сүсэг байдаг>> гэжээ. "Харин чи - хэмээн Заратустра, - Хорон санаат хөгшин шидтэн, юу хийх нь энэ вэ? Чи хүртэл иймэрхүү бурхан-илжгийг шүтэж байгаа бол энэ эрх чөлөөтэй зуунд хэн чамд хойшид итгэх юм бэ? гэв. Заратустра ичих нүүртэй хүнд хандан: Чи ч гэсэн үү ... Чиний сэтгэл энэ мөргөл, гэгээнтний хүж утлаганд хэтэрхий ариун биш билүү? гэв. Ичих нүүртэй хүн: Магадгүй би Бурханд итгэх эрхгүй байж болох юм, гэхдээ ийм дүртэй Бурхан надад илүү итгэлтэй санагдаж байгаа нь эргэлзээгүй"⁵. Достоевскийн хэлсэнчлэн "Бурхныг үгүйсгэнэ, тэгээд модон бурханд, эсвэл алтан бурханд, эсвэл сэтгэлээ буусан бурханд мөргөнө. Тийм хүмүүс бол бурхны дүрийг шүтэгсэд, гэхдээ сүсэггүйчүүд биш, тэднийг тэгж нэрлэх хэрэгтэй"⁶.

Хуучин гэрээний үед Мосегийн хуулиар хиймэл шүтээн шүтэж болохгүй тухай хуульчлан өгсөн. Тухайлбал "Египетээс гарсан нь" номын 20:4-5-д "Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй. Чи өөртөө зориулан шүтээн эсвэл дээр тэнгэр дэх, доор газар дахь, газрын доор усан доторх юмны ямар нэг дүрсийг бүү хий. Чи тэдэнд мөргөж, тэдэнд үйлчилж болохгүй" хэмээн

зарлигдсан хэдий ч Египетийн боолчлолоос гарсан израйлчууд тун удалгүй өөр нэгэн хиймэл шүтээн шүтэж эхэлдэг. Хуучин Гэрээний Египетээс гарсан нь номын 32:1-5д "1 Мосег уулаас бууж ирэлгүй саатсныг ард түмэн харахдаа, Аароныг тойрон цугларч, түүнд -Бос. Бидний өмнө явах бурхныг бидэнд бүтээж өг. Учир нь биднийг Египетийн нутгаас гаргасан хүн болох энэ Мосед юу тохиолдсоныг бид мэдэхгүй байна гэж хэлэв. 2 Аарон тэдэнд -Эхнэр, хөвгүүд, охидынхоо чихэнд байгаа алтан ээмгүүдийг тайлж, надад авчир гэв. 3 Бүх ард түмэн чихнээсээ алтан ээмгүүдээ тайлж, Ааронд авчрав. 4 Аарон тэдний гараас тэдгээрийг нь авч, сийлбэрийн багажаар урлан цутгамал тугалын дүр бүтээв. Тэд -Израильчууд аа, энэ бол та нарыг Египетийн нутгаас гаргасан та нарын бурхан юм гэгцгээв". Энд өгүүлж буй бурхан бол Христийн шашны бүхнийг бүтээгч, бүхний дээр оршигч, хаас сайгүй оршигч, төгс хүчит Бурхан биш, харин алтаар урласан тугал буюу хиймэл шүтээн юм.

Харин Шинэ гэрээний үед Христийн шашны элч Паул Афин хотод Эпикур, Стоикийн философичидтой хиймэл шүтээний талаар ярилцаж байна. Шинэ гэрээний "Үйлс" номын 17:29-д "Бурханы үр удам атлаа бид Бурханлаг Мөн чанарыг хүний санаа, урлагийн тусгалыг тээгч алт, мөнгө, эсвэл чулуун дүрстэй адилтган бодох ёсгүй" гэжээ. Берлиний Чөлөөт их сургуулийн хүмүүжил, сэтгэл судлалын факультетийн Антропологи, Хүмүүжлийн профессор Кристоп Вүльф "Боловсрол, хүмүүжил антропологийн үүднээс" номынхоо "Төсөөлөл ба хүний үүсэл" хэмээх хэсэгтээ төсөөлөл бол хүн байх буюу хүний мөн чанартай байх нөхцөл (human condition) хэмээн үзжээ. Түүний хувьд төсөөлөл нь байхгүй зүйлийг одоо цагт авчирдаг бөгөөд тогтосон хэв журмыг өөрчилж, шинийг бий болгох, эд юмс зохион бүтээх болон бүтээлч чадварыг хөгжүүлэхэд төсөөлөл чадвар чухал үүрэгтэй. Тэрээр хүний төсөөлөл чадварын илрэл нь зураг гэж үзсэн бөгөөд зураг нь зураг дээр байхгүй зүйлийг болон зураг дээр гарч болох зүйлийг харуулдаг аж. Хөшөө баримал, шүтээн, баг, тахин шүтэх агуулгатай зураг, шашны зураг нь Бурханы оршихуйг төлөөлүүлэн хүмүүсийн итгэх бишрэх, сүсэглэх хэрэгцээг хангаж иржээ. Эдгээрээс бурхадын оршихуйг төлөөлүүлэн

⁵ Мөн тэнд, 425 - 426 дахь тал.

⁶ Ф.М.Достоевский. Хөвүүн заяа. орч. Ц.Гомбосүрэн. УБ., 2016 он. 476 дахь тал.

дүрсэлсэн бурхадын зураг онцгой үүрэг гүйцэтгэдэг байна. Бурхадын зураг нь: “Хүч харамгүй холыг одоо цагт авчрах, энэ хүрэмгүй холыг оршихуйтай болгох, хүний анхаарлын орон зайг бүрэн дүүргэх чадвараас бий болдог. Зургийн хүч адил төстэй байхад оршдог бөгөөд зураг дүрсэлж буй зүйлтэйгээ адилхан болдог. Алтан тугал бол зан үйлийн үүднээс бурхан мөн. Зураг дүрс, түүний агуулга ялгагдахааргүй болтлоо хоорондоо уусдаг”⁷. Фридрих Ницше хэдийгээр “Бурхан үхсэн” гэсэн ч хүмүүс дахин шүтлэгтэй болдог тухай сануулсан байх талтай.

Хүн төрөлхтөнд өвөг дээдэсдээ өртэй гэсэн мэдрэмж нь он удаан жил хадгалагдан үлддэг бөгөөд үүний зэрэгцээ өөрсдийн “Бурхад өртэй хэмээх ухамсар болон мэдрэмж”⁸ нь мөн л олон мянган жилийн турш өсч хөгжихөө ер зогсоогүй гэж Ницше үзэж байжээ. Тэрээр хүн төрөлхтөний түүхэнд байсан бусад бүх бурхдаас хамгийн агуу нь Христийн шашны Бурхан гэж үзсэн бөгөөд энэхүү Бурхан гарч ирсэн явдал бол хүн өөрсдийн уг гарвал, анхны шалтгаандаа өр төлөөстэй гэдэг мэдрэмжийн агуу илрэл бөгөөд атеизмийн бүрэн гүйцэд, эцсийн ялалт нь хүн төрөлхтнийг өөрсдийнх нь өртэй гэсэн мэдрэмжээс чөлөөлөх явдал гэсэн юм. Шинэ гэрээний “Үйлс” номын 17:26-д “Бурхан газрын цээжээр амьдруулахаар нэгнээс хүмүүн төрөлхтний үндэстэн бүрийг бүтээж, товлосон цаг хугацаа болон тэдний нутаглах хил хязгаарыг тогтоосон” хэмээн гардаг. Христийн шашны хувьд хүн төрөлхтөн Бурханы бүтээсэн хорвоо ертөнц, гариг эрхэс дээр амьдарч, түүний таалал, ач ивээлээр хорвоогийн тоосыг хөдөлгөн Түүний Хүүд итгэх итгэлийн замаар дамжин аврагдах тухай сургаал бөгөөд энэ дэлхий дээрх юу ч биднийх биш, бидний бие махбодь, ахуй амьдрал, бидний оршин тогтнох дэлхий, амьдран суух улс орон хүртэл Бурханы бүтээл, хүсэл зориг, түүний төлөвлөгөөнийх гэж ойлгогдоно.

Христийн шашны Бурхан еврейчүүдтэй хамтгарчирсэн бөгөөд Ницше еврейчүүдийн

тухай зохиол бүтээлдээ багагүй хэмжээгээр дурдсан байдаг нь хожим еврейн эсрэг үзэлд томоохон хэрэглэгдэхүүн болсон байх талтай. Сурвалжит, язгууртан, хүчтэй, эзэд, хүчийг эзэмшигч эрх дархтай хүмүүсийн эсрэг еврейчүүдийн хийсэн зүйлтэй харьцуулж болох зүйл энэ дэхий дээр байхгүй гэж Ницше үзсэн бөгөөд еврейчүүд үнэлэмжийн эрс хувиргалтаар дамжуулан ялагч болж оюун санааны өшөө авсан гэжээ. Ницше “Эздүүдийг устгасаар байлаа. Энгийн, эгэл хүний ёс суртахуун л ялав” гэж бичиж байв. Энгийн, эгэл жирийн хүмүүс буюу ялсан тэдгээр хүмүүс боолууд, бөөгнөрсөн олон түмэн, сүрэг, борчуул хэн ч гэж дуудагддаг бай (Ницшегийн үгээр) Еврейчүүдийн ачаар л ялалтанд хүрсэн гэсэн. Тэрээр еврейчүүдийг “Өөр ямар ч ард түмэн ийм дэлхийн түүхэн үүрэгтэй байгаагүй”⁹ гэжээ.

Үнэлэмж хэрхэн хувирдаг вэ? Христ болон еврейчүүд үнэлэмжийг хэрхэн хувиргасан бэ? Ихэнх хүмүүс тухайнамаьдарч буй нийгмийнхээ сайн муу, нүгэл буяны талаарх үнэлэмжийг шүүмжлэлгүйгээр, ухамсаргүйгээр хүлээн авах хандлагатай байдаг ба энэ талаар Ницше биднийг бараг өлгийтэй бага байх үеэс л сайн мууг яаж үнэлэх өвийг өвлүүлэн үлдээдэг гэж үзсэн бөгөөд тэрээр Заратустрагийн үгээр “Олон түмний үндэслэлгүй итгэж сурсан зүйлийг хэн ул үндэстэй няцааж чадах билээ?” хэмээн асуудаг. Хэвшмэл ойлголтууд бол улс орон, ард түмэн, нийгмийн бүлгүүд болон хувь хүмүүсийн тодорхой шинж буюу зан байдлын хэв маягуудыг ерөнхийлсөн, хялбарчилсан байдлаар үнэлэн илэрхийлдэг. Улс төрийн удирдах эрх бүхий хүмүүс өөрсдийн бусдаас илт давуу байдлаа илэрхийлэхүйц үнэлэмжийн ойлголтуудыг нийгэмд тогтоож байдаг бол нөгөө талд хэрэв улс орныг удирдан залж чиглүүлэх үүрэг бүхий удирдах эрх бүхий дээд анги нь санваартнууд, тахилч тайлгачдаас (priest caste) бүрдсэн бол тэд өөрсдийнх нь үүрэг даалгаварыг сануулж байхуйцаар үнэлэмжүүдийг тогтоож байдаг гэж Ф. Ницше үзсэн. Жишээ нь: анхандаа цэвэр болон цэвэр бус хэмээх үгс нь хүмүүсийн нийгмийн статусыг илэрхийлэх байдлаар хэрэглэгддэг байсан бол яваандаа

⁷ Кристоф Вүльф. Боловсрол хүмүүжил антропологийн үүднээс. орч. А.Уянга. Ж.Отгонбаяр. Г.Ариунцэцэг. УБ. 2015 он. 88 дахь тал.

⁸ Friedrich Nietzsche - On the Genealogy of Morals. Translated by Ian Johnston of Malaspina University-College. Nanaimo. BC. Canada. page 46.

⁹ Friedrich Nietzsche - On the Genealogy of Morals. Translated by Ian Johnston of Malaspina University-College. Nanaimo. BC. Canada. page 13.

сайн болон муу нь хүний нийгмийн статусыг илэрхийлэхээ больсонтой адилаар хэрэглээний утгаа алдан өөр утгатай болжээ. Хүмүүс цэвэр болон цэвэр бус хэмээх санаануудыг хэтэрхий чухалчлан, хэт ерөнхийлөн эсвэл бэлгэдлийн байдлаар авч үзэх ёсгүй гэж Ницше сануулсан бөгөөд цэвэр хүн гэдэг нь анхандаа “усанд ордог, арьсны өвчлөл үүсгэж болохуйц хоол унднаас татгалздаг, доод гарлын бохир эмэгтэйтэй унтдаггүй”¹⁰ тиймэрхүү хүнийг илэрхийлдэг байсан байна. Фридрих Ницше хэл судлаачийн хувьд сайн, муу гэх мэт үгсийн үгийн гарвал зүйн талаар судлаж байжээ. Сайн хэмээх үгийн илэрхийллийн утга нь өөр хэлнүүдэд үгийн гарвал зүйн үүднээсээ яг ямар утгатай вэ? гэж асуусан. Тийнхүү тэрээр сайн хэмээх ойлголт нь нийгмийн утгаараа хаана сурвалжит, язгууртан гэж байна энэ нь оюун санааны хувьд язгууртанлаг, оюун санааны хувьд өндөр зэрэглэлийн, оюун санааны хувьд эрх дархтай гэсэн утгаас үүсэн гардаг ба энгийн, эгэл, бүдүүн баараг, доод зэргийг муу руу хувирдаг ойлголттой зэрэгцэн оршиж зайлшгүй хөгжиж байдаг гэсэн.

Сайн ба муу, нүгэл ба буян хэмээх хоёр үнэлэмжийг Ницше “Ром Еврейн эсрэг, Еврей Ромын эсрэг” хэмээн тодорхойлсон. Ницшегийн хувьд Ромчууд дэлхий дээр амьдарч байсан бүх хүмүүсээс хамгийн хүчирхэг, сурвалжит язгууртан хүмүүс бөгөөд “Араб, Герман, Японы сурвалжит язгууртнууд, Гомерийн баатрууд, Скандинавын викингүүд”¹¹ ч мөн хүчирхэг, сурвалжит хүмүүс ажээ. Ницше “Цаг хугацаа өнгөрөн одохуй дор тэдний хэн нь ялалтаа бататгасан бэ? Ром уу? Еврей юу? Үнэндээ эргэлзэх зүйл алга. Өнөөдөр Ромд бүхий л агуу үнэлэмжүүдийн биелэл болсон хэнд өвдөг сөгдөцгөөж байгаа тухай бодож үзнэ үү, зөвхөн Ромд ч биш дэлхийн хагаст нь, хүмүүс ердөө л гэршүүлсэн амьтад болсон эсвэл гэршүүлсэн амьтад мэт болохыг хүссэн бүхий л газар, гурван эрэгтэй ба нэг эмэгтэй еврей өмнө бөхийнө. Назаретын Есүс, загасчин Петр, хивсчин Паул, Есүсийн эх гэгдэх Мариа”¹² гэжээ. Түүний хувьд уг нь бол Ром ялсаар

ирсэн бөгөөд Сэргэн мандалтын үе бол гайхамшигтай эрин үе байсан бөгөөд сонгодог бүх л санаануудын болон бүх зүйлийг үнэлэх, үнэлж цэгнэх сурвалжит шинж чанар дахин сэргэсэн үе мөн. Энэ үед Ром бүхэлдээ дэлхийг хамарсан шинжтэй синагог болон сүм хэмээн нэрлэгдсэн Еврейн дарамтаас сэрсэн мэт байсан гэж Ницше үзсэн бөгөөд гэвч удалгүй сүмийг дахин шинээр зохион байгуулсан Дахин шинэчлэлтийн үед Еврейчүүд ялсан ажээ. Еврейчүүд болон Христийн шашин сайны тухай анхны үнэлэлэмжийг муу хэмээн муугийн тухай үнэлэмжийг сайн хэмээн өөрчилсөн. Ром буюу сайн муугийн талаарх анхны үнэлэмж болон Еврей-Христийн шашны сайн муугийн үнэлэмжийн тэмцэл дунд сүүлд Ромын талд Наполеон гарч ирсэн бөгөөд түүнийг цор ганц ба хожуу төрсөн хувь хүн, сурвалжит язгууртанлаг шинж бүрэн цогцолж биелэлээ олсон хүн хэмээн Ницше тодорхойлсон.

Шинжлэх ухаан, техник технологийн хөгжил дэвшил нь олон хүмүүсийг аливаа асуудалд шашин болон сүсэг бишрэлийн үүднээс хандахгүй байхад нөлөөлдөг. Фридрих Ницше шинжлэх ухаанч сэтгэлгээгээр аливаад хандаж байсан ба амьдарч байсан цаг үеэ “манай үе бол мэдлэгийн үе”, хүмүүсийг “эрдэм мэдлэгтэй хүмүүс” хэмээн тодорхойлсон байдаг. “Манай одоо үеийн шинжлэх ухаанч чанарын бүх арга, бүх урьдчилсан нөхцөлүүдийг мянга мянган жилийн туршид огт тоомсорлодоггүй байв, тэдгээрээс болж зарим нэг хүн үнэнч шударга хүний тооноос хасагдаж, үнэнийг тоомсорлодоггүй Ертөнцийн эзний дайсан, солиотой этгээд гэж тооцогддог байв”¹³. Түүнийхээр шинжлэх ухааны мэдлэг нь таамаглал, төсөөлөлгүйгээр оршиж чадахгүй бөгөөд философи болон сүсэг бишрэлээс шинжлэх ухааны мэдлэг нь өөрийн зүг чиг, мэдрэхүй, хил хязгаар, арга, зөвтгөл, оршихуйгаа олж авдаг байна. “Бидний шинжлэх ухаанд итгэх итгэл маань одоо хүртэл метафизик итгэл үнэмшил буй ямар нэг юманд тулгуурладаг ба өнөө цагийн эрдэм мэдлэгтэй, бурхангүй, анти-метафизик хүмүүс бид одоог хүртэл хоёр мянган жилийн өмнө ассан Бурхан бол

¹⁰ ibid. page 10.

¹¹ Friedrich Nietzsche - On the Genealogy of Morals. Translated by Ian Johnston of Malaspina University-College. Nanaimo. BC. Canada. page 16.

¹² ibid. page 23.

¹³ Фридрих Ницше, Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу Эллин ёс ба гутрангуй үзэл, Христэд тэрслэгч. орч. О.Чимэг. УБ. 2012 он. 189 дахь тал.

үнэн, үнэн бол тэнгэрлэг гэсэн Христэд итгэх итгэл, мөн Платоны ч итгэл үнэмшил байсан тэрхүү итгэл үнэмшлийн дөлөөс өөрсдийн галаа авсан”¹⁴ гэжээ.

Ф. Ницше Хуучин гэрээнд өгүүлэгдэх дэлхийн бүтээлтээс эхлээд Ноагийн үер хүртэлх түүхийг хураангуйлан Христийн шашин нь шинжлэх ухаан болон шинжлэх ухаанч сэтгэлгээтэй дайсагналцдаг хэмээн дүгнэлт хийсэн. Ницше: “Библийн эхэнд орсон алдартай үйл явдал, - шинжлэх ухааныг хараад Ертөнцийн эзэн айхтар их айсан тухай үйл явдлыг хэн нэгэн жинхнээр нь ойлгосон болов уу?” ... хэмээн асуусан. Тэрээр хөгшин Бурхан (Der alte Gott) уйдагдаа хүнийг бүтээж, хүн ч уйдахад түүнд амьтдыг бүтээж өгсөн ба хүн сэтгэл ханаагүй тул эмэгтэй хүнийг бүтээсэн гэжээ. (Ницшегийн хэрэглэсэн зүйр үг: Уйдахын эсрэг тэнгэр бурхдын тэмцэл хүртэл талаар болдог/Against boredom even gods struggle in vain). Эмэгтэй хүн ч уйдсан. Христэд тэрслэгч номынхоо 49 дүгээр хэсэгт: “Хүн өөрөө ертөнцийн эзний аугаа их алдаа болов, түүнийг бүтээхдээ тэр өрсөлдөгчөө бүтээчихжээ: шинжлэх ухаан Ертөнцийн эзэнтэй тэнцүү болгодог, -хүн шинжлэх ухааныг таньж мэдэж эхлэхэд тайлгачдын болоод тэнгэр бурхдыг төгсгөл ирдэг” гэжээ. Ницшегийн хувьд Библийн Эхлэл номон дахь Адам Ева хоёрын уналт хэмээн нэрлэгддэг тэрхүү үйл явдал бол хүний танин мэдэх хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлын илрэл бөгөөд Бурхан танин мэдэх оролдлогыг, шинжлэх ухааныг хориотой зүйл болгожээ. “Шинжлэх ухаан бол – хүний эхний нүгэл, бүх нүглийн үр хөврөл, үүсгэл нүгэл”. Ертөнцийн Эзэн шинжлэх ухаанаас өөрийгөө хамгаалах хэрэгтэй болсон бөгөөд хүнийг диваажингаас зайлуулсан (Едений цэцэрлэгээс хөөсөн). Ницшегийн хувьд Бурхан болон түүний санваартан/тайлгач тахилч хүний хувьд хүн төрөлхтөн бодож сэтгэх ёсгүй бөгөөд “аз жаргал, зав чөлөө хүнийг бодолд автагдуулдаг” тул бодол санааг нь сатааруулахаар, шинжлэх ухаантай тэмцэлдэхээр “үгээгүй байдал, үхэл, амьдралд учруулдаг аюул заналхийлэл бүхий жирэмслэлт, элдэв төрлийн гай гамшиг, хөгшрөх, амьдралын дарамт,

өвчин” зохион бүтээсэн аж.

“Хөдөлмөрийг ер нь зовлон гэдэг үзэл иудей-христийн уламжлалаас язгууртай. Адам, Ева хоёр диваажингийн цэцэрлэгт ажиллаж байгаагүй; чухамхүү анхны нүглийнх нь шийтгэл болгож Бурхан хүнийг амь зуухын тулд хөлсөө гаргах ёстой гэж шийдсэн. Христийн шашны уламжлалаар үхлийг нэг насаараа хийх ёстой хүнд хүчир хөдөлмөрийн дараа тохиох амсхийлт гэж үздэг; тийм учраас булшны чулуун дээр Requiescat Pacem (Rest in Peace) гэж бичдэг”¹⁵. Гэвч тэдний төлөвлөснөөр үгээгүй байдал хүнд бодох бололцоо олгохгүй байх байтал “танин мэдэхүйн үйл хэрэг тэнгэр хүртэл сүндэрлэж, тэнгэр бурхдыг халхлан босно” буюу хүн төрөлхтөн тэнгэрт гарч Бурхантай уулзахаар Бабелийн цамхаг барив. Тийнхүү Ертөнцийн эзэн хүмүүсийн хэл яриаг бусниулж, улс түмнүүдийг салган тусгаарлаж, дайныг зохион хүмүүсийг нэг нэгнийгээ харилцан устгахад хүргэсэн байдал бий болгон дайн дажин нь бусад хүчин зүйлстэй зэрэгцэн шинжлэх ухаанд аугаа их саад тотгор болно гэж тооцоолсон ч хүмүүс өөрсдийгөө Бурханаас түүний санваартан/тахилч тайлгачдаас чөлөөлөх үйл явц үргэлжилсээр байсан бөгөөд хүн аль хэдийн шинжлэх ухааныг танин мэдэж эхэлсэн тул тэднийг живүүлж алах (их үер) хэрэгтэй болсон хэмээн Ницше тайлбарлажээ.

Тэрээр Христэд тэрслэгч номынхоо 25 дугаар хэсэгт хөгшин бурхан урьд нь чаддаг байсан юугаа ч хийж чадахаа больсон бөгөөд аливаа аз жаргалыг шагнал, аливаа золгүй явдлыг дуулгаваргүй байсны шийтгэл, нүгэл гэж тайлбарлах болсон санваартнуудын зэвсэг болж хувирсан гэсэн. Санваартнуудад дуулгаваргүй байх нь нүгэл болж Ертөнцийн Эзэнтэй эвлэрэх арга хэрэгсэл нь санваартанд улам баттай захирагдах аж. Ёс суртахууны үүсэл гарвал номондоо Фридрих Ницше “гэм буруу, нүгэл, нүгэлт байдал, буурал доройтол, зүхэл гэсэн санаануудыг парадокслог логикийн бус санаанууд”¹⁶ гэсэн байдаг.

Ницше Шүтээний бууралт (Twilight of idols) номынхоо “Жинхэнэ ертөнц эцэстээ

¹⁴ Friedrich Nietzsche - On the Genealogy of Morals. Translated by Ian Johnston of Malaspina University-College. Nanaimo. BC. Canada. page 84.

¹⁵ Фрэнсис Фукуяма. Итгэлцэл (Нийгмийн буян, хөгжин цэцэглэх зам). орч. Ц.Гомбосүрэн. УБ. 2014 он.

¹⁶ Friedrich Nietzsche - On the Genealogy of Morals. Translated by Ian Johnston of Malaspina University-College. Nanaimo. BC. Canada. page 70.

хэрхэн домог болсон тухай, Алдааны түүх” (How the true world finally became a fable. The history of error) хэмээх хэсэгт ертөнцийн талаарх Платоны, Христийн шашны, Кантын үзэл санааг хураангуйлсан байдаг. Платон нь ертөнцийг бидэнд сэрлээр дамжиж харагддаг үзэгдлийн, оюун ухаан болон сэтгэхүйгээр дамжуулан хүлээн авдаг санааны ертөнц хэмээн ангилсан бол Кант ертөнцийг мэдрэхүүд өртөгдөх үзэгдлийн буюу феноменаль, мөн чанарын буюу ноуменаль хэмээн ангилсан ба тэрхүү мөн чанарын ертөнцийг танин мэдэх боломжгүй гэдэг. Гэтэл Ф.Ницше “зөрчилтэй санаанууд болох цэвэр оюун ухаан, туйлын оюун санаа, өөртөө буй юм”¹⁷ гэх зэрэг хуучны үзлийн фантазаас өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй бөгөөд эдгээр нь биднээс төсөөлж боломгүй зүйлсийг төсөөлөхийг шаарддаг гэж үзсэн. Түүнийхээр иймэрхүү ойлголтууд нь ямар ч зүг чиг, чиглэл байхгүй, тиймд эдгээр зүйлс нь ойлголтын хувьд хоосон бөгөөд абсурд зүйлсийг харахыг шаарддаг. Ницшегийн хувьд энэ ертөнцөөс өөр ямар нэгэн өөр ертөнц байхгүй. “Бүхий л нөгөө ертөнц зовлон шаналал, аргагүйдлээс бүтсэн. Хамгийн их шаналсан хүний амсдаг тэрхүү ахархан аз жаргалын солиорлоос бүтдэг. Үхлийн үсрэлтээр ганц үсрээд л эцэст нь хүрчихийг хүссэн туйлдаг л бүх бурхад, нөгөө ертөнцийг бүтээдэг. Гэвч нөгөө ертөнц, тэрхүү хүнгүй, хүний гэх юмгүй болсон тэнгэрийн Юу ч бишээс тогтсон ертөнц хүнээс хангалттай далд байдаг. Аливаа оршихуйг багтах үнэнхүү хэцүү”¹⁸. Христийн шашин нь нүглээ наманчлагч, итгэгч сүсэгтэн амилуулалтаар дамжин там, диваажин, Бурханы хаант улсад хүрэх сургаал номлол юм.

Фридрих Ницше Есүс Христийн тухайд “...түүнийг хэн алав? түүний жам ёсны дайсан хэн байв? – энэ асуулт цахилгаан цохих шиг гэнэт санаанд оров. Хариулт нь: ноёрхогч иудей тогтолцоо, түүний дээд давхарга”¹⁹ гэсэн бөгөөд фарисайчууд бол Мосегийн хуулийг хатуу чанд баримталдаг, ихэд шүтлэгтэй хүмүүсээс бүрдсэн иудейчүүдийн бүлэглэл юм. Шинэ гэрээнд бичигдсэн фарисайчууд бол Есүсийг

үзэн ядагч, атаархуу, өөнтөгч, софизм хэрэглэж түүнийг үгээр давахыг оролдогч, нэр хүнд албан тушаалаа алдахвий гэж айсан нэр нөлөө бүхий хүмүүс бөгөөд эцэстээ Христийг цовдлогдоход хүргэсэн юм. Ницше “Заратустра ингэж хэлсэн” зохиолдоо фарисай гэдэг үгийг хэрэглэхдээ Шинэ гэрээн дэх агуулгатай нь адилаар шинэ үнэлэмж, аливаа шинэ соргог бүхнийг үзэж чаддаггүй хуучинтайгаа зууралдсан байдлыг шүүмжлэхийн зэрэгцээ сайхан сэтгэлтэй, сайн хүмүүс гэж нэрлэгддэг хүмүүсийг шүүмжлэх утгаар хэрэглэсэн ба Христийг өмөөрсөн өнгө аястай зүйлс харагддаг.

Ницше бурхадын үхлийг тунхагласнаараа хүн төрөлхтөний баримталдаг алив үнэлэмжийн цогц, уламжлан авсан бүхий л үнэлэмжийг дахин шинээр үнэлэхийг хэлсэн. Бурхан үхэхэд үлдсэн тэрхүү хоосон орон зайг үлэмж хүн, ер бусын хүн, сод хүн, хэмээн орчуулж болох өөрөө өөрийгөө ялан дийлсэн, өөрөө өөрийнхөө эзэн болсон, бурхангүй (Godless) хүмүүс эзлэх ёстой болов. Ер бусын хүн: “Би та нарт ер бусын хүний тухай хэлж өгье. Хүн бол давж гарах ёстой л нэгэн зүйл. Хүнийг давж гарахын тулд та нар юу хийсэн бэ? Бүхий л амьтас өөрөөсөө дээд ямар нэг юм бүтээсээр өдийг хүрсэн. Харин та нар хүнийг давж гарахын оронд тэр агуу давалгаанд цохигдож, адгуусны байдалдаа хурдхан буцаж очихыг хүсэж байна уу? Хүнтэй харьцуулахад сармагчин юу вэ?”²⁰. Бурхан үхсэнээр хүн төрөлхтөний итгэл найдварталаар өнгөрч, ёс суртахууны зүг чиг алдагдаж, амьдралын зорилго эрхэмлэлгүй болох аюултай бөгөөд Ницшегийн үгээр христийн шашны “санаанаасаа зохиосон зорилго зүй: Бурханы хаант улс, диваажин, мөнх амьдрал” худал хуурмаг болно. Фридрих Ницше нигилист байсан уу? Иван Тургеневийн Эцэг, хүүхэд зохиолд нигилист үзэлтэй Базаров хэмээх залуу гарах бөгөөд нигилист үзэлтэн нь “юуг ч хүлээн зөвшөөрдөггүй, юуг ч ойшоодоггүй хүн, юм бүхнийг шүүмжлэлтэйгээр авч үздэг хүн”, “Алив нэр цуутанд биширдэггүй, хэдий их итгэл хүндтэй зарчим байлаа гэлээ ч, нэг ч зарчмыг итгэж дагадаггүй хүнийг нигилист гэж байгаа юм”²¹ хэмээжээ. “Би

¹⁷ ibid. page 64.

¹⁸ Фридрих Ницше. Заратустра ингэж хэлсэн. орч. Б.Батаа. УБ. 2014 он. 33-35 дахь тал.

¹⁹ Фридрих Ницше. Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу Эллин ёс ба гутрангуй үзэл. Христэд тэрслэгч. орч. О.Чимэг, УБ, 2012 он. 225 дахь тал.

²⁰ Фридрих Ницше. Заратустра ингэж хэлсэн. орч. Б.Батаа. УБ. 2014 он. 8 дахь тал.

²¹ И.С.Тургенев. Эцэг, хүүхэд. орч. Ш.Очирбат. УБ. 2016 он. 31

хүмүүст тэдний амьдрал ахуйн утга учрыг зааж өгмөөр байна. Энэ утга учир бол хүн хэмээх хар үүлэнд цахилсан аянга, ер бусын хүн”²². Ницше христийн шашныг шүүмжлэн хүн хуучны үнэлэмжийн тогтолцооноос ангижирч, өөрөө өөрийнхөө эзэн болж, амьдралд за гэж хэлж, өөрийг нь дарах дарамтлах бүгдийн өөдөөс үгүй гэж хэлж чаддаг жирийн хүнээс илүү гарсан тийм хүн болох хэрэгтэй гэсэн.

Супер хүний тухай Ницшегийн үзэл бол бие махбодь физиологийн бус, сэтгэл зүй психологийн өндөр чадвартай хүний тухай бөгөөд одоо цагийн хүн цаашид хувьсан өөрчлөгдөж, хөгжихдөө ямар болохыг, ямар болох хэрэгтэйн тухай үзэл санаа юм. “Бидний зам нэг төрлөөс нөгөө төрөл рүү, илүү дээд төрөлтөн рүү дээшээ явдаг”²³. *Übermensch* болохын тулд хүний сэтгэл, оюун ухаан хөгжлийн дараах гурван үе шатыг дамждаг. “1. “Тэмээ”- хүн буюу соёлын уламжлал, өмнө хүеийнхээ уламжлалыг өөртөө тээсэн хүн. 2. “Арслан”- хүн буюу өөрийнхөө тэмээ болохыг үгүйсгэсэн хүн, өөрөөр хэлбэл хүнээс хамаарах бүх зүйлсээс бүрэн татгалзсан хүн. 3. “Хүүхэд”- хүн буюу цэвэр хуудас шиг цоо шинэ хүн, өөрөөр хэлбэл өөрийн зориг, хүслийг чиглүүлэгч хуулийг өөртөө бүтээсэн хүн”²⁴. Сэтгэлийн хоёр дахь хувирал бол арслан болох юм. Сэтгэл арслан төлөвт шилжин хувирахдаа өөрийн эрх чөлөөгөө олохыг, элсэн цөлдөө (амьдралдаа) эзэн болохыг хүсдэг аж. Ницше “Заратустра ингэж хэлсэн” номынхоо Гурван хувирлын тухай (сэтгэлийн гурван хувирал) хэмээх хэсэгтээ “Сэтгэл энд (цөл буюу амьдрал) сүүлийн эзнээ хайдаг. Эзнийхээ буюу сүүлчийн бурхны дайсан болохыг хүсдэг. Тийнхүү ялалт байгуулахын тулд агуу луутай тэмцэхийг хүсдэг. Сэтгэл өөрийнхөө эзэн, бурхан гэж дахиад нэрлэхийг хүсэхгүй байгаа тэр агуу луу юу вэ? Түүний нэр <<чи тэгэх ёстой>>. Тэгвэл арслангийн сэтгэл <<би хүсэж байна>> гэдэг. Бүхий л үнэт зүйлийг нэгэнт бүтээчихсэн. Тиймээс бүтээсэн үнэт зүйл бүхэн – би. Үнэндээ <<би хүсэж байна>> байх ёсгүй. Луу ингэж

хэлдэг”²⁵. Энэхүү зохиолд өгүүлсэнээр луу бол хуучны үнэлэмж, сайн муугийн үнэлэмжийг тогтоогч, хөгшин бурхан, христийн шашны бурхан гэсэн утгатай. “Чи тэгэх ёстой” гэдэг нь Мосегийн арван хуулийн “чи тэгэх ёсгүй” гэдгийг ёжлон тэрхүү хуулийг өгсөн Христийн шашны Бурханыг өгөөдөн хэлж буй. Ницшегийн “Ёс суртахууны үүсэл гарвал” номон дахь “tables of value” бол “Заратустра ингэж хэлсэн” номны “Шинэ, хуучин самбарын” тухай (Old and new tables) хэмээх хэсэгтэй адил ба Хуучин гэрээнд израйльчууд Египетийн боолчлолоос чөлөөлөгдөн нүүдэллэсээр Синаи ууланд хүрдэг ба Мосе тэрхүү ууланд гарч Бурхантай уулзан гэрчлэлийн хоёр хавтан хэмээн нэрлэгдсэн чулуун хавтан авчирдаг. Эдгээр чулуун хавтанг: Бурханы мутраар бичигдсэн, Бурханы бүтээл, Бурханы бичээс хэмээн тодорхойлжээ. Мосе уулнаас бууж ирэхэд израйльчууд алтан тугал хийгээд шүтэж байсанд ихэд уурлан хавтанг хэмхлэн хаясан байдаг.

Сэтгэл зүйчийнх нь хувьд түүнээс суралцсан цорын ганц хүн бол Достоевский гэж Ницше хэлсэн байдаг. Тэрээр Фридрих Ницшегийн философи сэтгэлгээнд нөлөөлсөн олон хүний нэг мөн бөгөөд чухам үүнийг батлах мэт түүний эх зохиолуудад Ницшегийн үзэл санаатай давхцах төстэй хэсгүүд ажиглагддаг. Ницше Заратустрагийн үгээр “Бурхан бол таамаглал. Харин би та нарын таамгийг бүтээлч хүсэл зоригоос чинь цааш битгий сунжраасай гэж хүсэж байна. Та нар Бурхныг бүтээж чадах уу? Тэгвэл бурхны тухай надад битгий ярь! Харин та нар ер бусын хүнийг бүтээж чадах нь дамжиггүй. Бурхан бол таамаглал; гэхдээ би та нарын таамаглалыг сэтгэж болох хүрээнд хязгаарлагдаасай гэж хүсэж байна”²⁶ хэмээн хэлсэн бөгөөд Достоевскийн зохиолд “Бурхан бол ердөө л таамаглал ... гэхдээ... дэг журмын хувьд... орчлонгийн дэг журам гэх мэтэд түүний хэрэгтэй гэдгийг би хүлээн зөвшөөрдөг... хэрэв Бурхан байгаагүй бол Түүнийг бодож олох хэрэгтэйсэн”²⁷ гэжээ. Ницшегийн мөнхийн буцалт хэмээх санаатай тун

дэх тал.

²² Фридрих Ницше. Заратустра ингэж хэлсэн. орч. Б.Батаа. УБ. 2014 он. 19 дэх тал.

²³ Мөн тэнд 96 дахь тал.

²⁴ Философи дахь гайхамшигт 50 санаа. “Бурхан нас барлаа, төгс хүн мандтугай”. УБ. 2011 он. 172 дахь тал.

²⁵ Фридрих Ницше. Заратустра ингэж хэлсэн. орч. Б.Батаа. УБ. 2014 он. 26-27 дахь тал.

²⁶ мөн тэнд. 108 дахь тал.

²⁷ Ф.М.Достоевский. Карамазовын хөвүүд. Орч. Ц.Гомбосүрэн. УБ. 666 дахь тал.

адилаар “Энэ одоогийн газар чинь өөрөө тэрбум удаа давтагдсан ч байж ч магадгүй; яахав, мөхөөд, мөстөөд л, хагараад л, бутраад л, эхлэх бүтэц болон задраад л, дахиад нар, дахиад нарнаас газар дэлхийг үйсэн ус, дараа нь дахиад сүүлт од, дахиад нар, дахиад нарснаас газар энэ чинь хөгжил шүү дээ, бүр эцсийн ганц зураасаа хүртэл яг нэгэн зүйл хэлбэрээр хязгааргүй олон удаа давтагдаж байгаа байж магадгүй”²⁸ хэмээн бичжээ. Достоевскийн Карамазовын хөвүүд зохиолд хүн төрөлхтөнд байгаа Бурханы тухай санааг л бусниулах хэрэгтэй, хүн төрөлхтөн толгой дараалан Бурханаас няцах юм бол ертөнцийг үзэх урьдийн бүх үзэл сүйрч, урьдийн ёс суртахуун сөнөж, бүх юм шинээр эхэлнэ гэсэн. Үнэлэмжийн талаар Ницше дараах гурван санааг илэрхийлсэн бөгөөд энэ нь нэгд: бүх үнэлэмжийг дахин шинээр үнэлэх хэрэгтэй, хоёрт: аливаа аугаа үнэлэмжүүд өөрийгөө үнэлэмжгүйдүүлж байдаг, гуравт: философичдын үүрэг бол үнэлэмжүүдийг эрэмбэлэх явдал юм. Достоевскийн зохиолд “Бурхан бас мөнхрөл гэж ямартай ч байхгүй болохоор, шинэ хүн маань, мэдээж, шинэ дэв зэрэгтэйгээр, шаардлагатай бол хуучны боол - хүний урьдын ёс суртахууны элдэв хориг хаалтны дээгүүр санаа амар харайж гараад үгүйдээ бүхэл бүтэн хорвоод ганцаараа ч гэсэн хүн - бурхан болж болно”²⁹ гэжээ.

Фридрих Ницше христийн шашныг шүүмжлэхдээ еврейчүүдийн тухай багагүй дурдсан байдаг нь хожим еврейн эсрэг үзэлд ашиглах хэрэглэгдэхүүн болсон байх талтай. Түүний философи үзлийг нацизмын үзэл санааны суурийг тавихад нөлөөлсөн мөн өөрийн өсч өндийсөн европын соёл иргэншлийн гол тулгуур болох христийн шашныг эсэргүүцэн жигшин зэвүүцэгч гэж үздэг. Гэвч Ницшегийн эх зохиолуудад үндэслэн нарийн судалгаа хийх аваас тэрээр Бурхан үхсэний дараа хүн төрөлхтөнд дахин шинэ шүтээний хэрэгцээ гарч үүнээс улбаалан төрийг шүтэж эхэлдэг тухай анхааруулсан, шинжлэх ухаан болон техник технологийн хөгжил нь шашинд итгэх итгэлийг ганхуулж байгаа тухай бичсэн байдаг. “Бурхан үхсэн” хэмээх Ницшегийн үзэл атеист теистуудын хоорондын маргааныг улам ээдрээтэй болгосон бөгөөд тэрээр бурхан байдаг эсвээс бурхан

байдаггүй ч гэж үзэлгүйгээр нэгт, оршин байсан бурхан үхэж байхгүй болсон хоёрт, бурхан гэж үздэг шүтээн нь хүн эсвэл, хүний бүтээл байдаг гэжээ. “Бурхан үхсэн” хэмээх үзэл санааг ойлгохын тулд “Хэн Бурханыг хөнөөсөн бэ?” гэдгийг олж илрүүлэх ёстой. Фридрих Ницше, өөрийгөө төлөөлүүлэн илэрхийлсэн “Заратустра ингэж хэлсэн” зохиолын гол дүр бол Заратустра ч Бурханыг хөнөөгөөгүй. Ницшегийн хувьд загалмай дээр цовдлогдож нас барсан Есүс Христийн үхэл бол Бурханы үхэл ба бурханыг хөнөөсөн алуурчин бол Христийн арван хоёр шавийн нэг Иудас, Заратустра ингэж хэлсэн зохиолын нэгэн дүр болох хамгийн муухай хүн, хүнтэй адил боловч хүн гэж дүрсэлшгүй нэгэн юм. Түүний Антихрист зохиол герман хэлээр Христэд тэрслэгч эсвэл Христийн шашинтныг эсэргүүцэгч гэсэн хоёр утга илэрхийлнэ. Энэхүү номынхоо үндсэн утгаар дамжуулан Есүс Христ хэмээх хүний мөн чанар, түүний хүн төрөлхтөнд үлдээсэн өв, сургааалийнх нь онцлог зэргийг шүүмжилсэн бол уг номынхоо дагалдах утгаар дамжуулан Христийн шашныг тогтолцоо, сургаал номлол, институтжсэн байгууллага болохынх нь хувьд мөн христийн шашинтай хүмүүсийг шүүмжилжээ. Заратустрагаар дамжуулан Ницше хүн өөрөө өөрийгөө хуучны үнэлэмжийн тогтолцоо, бурхадаас хэрхэн чөлөөлөх тухай, яаж супер хүн болох сэтгэлзүйн процессыг дэлгэн харуулжээ. Бурхан үхсэн хэмээх хэллэгийг стереотипийн түвшний хэрэглээнээс гаргаж ойлгох ёстой бөгөөд Заратустра ингэж хэлсэн зохиолд бурхан үхээгүй ч байж магадгүй, эргээд амилсан ч байж болох тухай мөн хүн төрөлхтөн үргэлж тахин шүтэх шүтээн, бурхадын хэргэцээтэй байдаг тул өөр бурхад гарч ирсээр байх тухай сануулжээ. Ницшегийн хувьд аливаа төрлийн итгэл үнэмшлээс чөлөөтэй байна гэдэг бол хүч чадал, чөлөөтэй харах чадвар бөгөөд аугааг хүсч буй, аугаад хүрэх арга хэрэгсэлтэй байхыг хүсэгч оюунтан, оюуны хүч чадлыг эрхэмлэгч нэгэн зайлшгүй үл итгэгч байх аж. Тийм учраас тэрээр “итгэл үнэмшил бол шорон” гэж үзсэн. Ницшегийнхээр хүн Бурхангүй байсан нь дээр, ямар ч гэсэн хувь заяагаа өөрөө зохиосон нь дээр. Харин итгэлийн хүн, элдэв төрлийн сүсэгтэн хүн бол зайлшгүй хараат буюу өөрийгөө зорилго болгон тавьж чадахгүй, ерөөс

²⁸ мөн тэнд. 778 дахь тал.

²⁹ мөн тэнд. 784 дахь тал.

өөртөө түшиглэн зорилго болгон тавих чадваргүй хүн. Сүсэгтэн хүн өөртөө эзэн бус, тэр зөвхөн арга хэрэгсэл байж чадна, тэр ашиглагдах ёстой, тэр түүнийг ашиглах өөр хэн нэгний хэрэгцээтэй байдаг ба өөрийгөө бодохгүй байх ёс суртахууныг юу юунаас илүү дээдлэн хүндэлдэг учир элдэв төрлийн итгэл бол өөрийгөө үл бодсоны, өөрөөсөө хүнийссэний илэрхийлэл ажээ.

НОМ ЗҮЙ

1. Ариун Библи. Ариун Бичээс Библийн Нийгэмлэг. УБ. 2004 он.
2. Кристоф Вүльф. Боловсрол, хүмүүжил антропологийн үүднээс. орч. А.Уянга, Ж.Отгонбаяр, Г.Ариунцэцэг. УБ. 2015 он.
3. И.С. Тургенев. Эцэг, хүүхэд. орч. Ш.Очирбат. УБ. 2016 он.
4. Фридрих Ницше. Заратустра ингэж хэлсэн. орч. Б.Батаа. УБ. 2014 он.
5. Фридрих Ницше. Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу Эллин ёс ба гутрангүй үзэл, Христэд тэрслэгч. орч. О.Чимэг. УБ. 2012 он.
6. Ф.М.Достоевский. Карамазовын хөвүүд. орч. Ц.Гомбосүрэн. УБ.
7. Философи дахь гайхамшигт 50 санаа. УБ. 2011 он.
8. Bertrand Russell. History of Western Philosophy. A Touchstone book.
9. Frederick Copleston . A History of Philosophy, Vol. 7: Modern Philosophy - From the Post-Kantian Idealists to Marx, Kierkegaard, and Nietzsche.
10. Friedrich Nietzsche - On the Genealogy of Morals, Translated by Ian Johnston of Malaspina University-College, Nanaimo, BC, Canada.
11. Friedrich Nietzsche. Thus Spoke Zarathustra and Beyond good and evil. A Bedside classic. Liaoning People's Publishing House. 2013. China.
12. Friedrich Nietzsche. Thus Spoke Zarathustra. Oxford world's classics. new translation by Graham Parkes. 2005.
13. Keith Ansel Pearson. A Companion to Nietzsche. Blackwell Publishing. 2006,. Australia.

14. Robert C. Solomon. Existentialism. Modern Library College Editions. 1974. USA.
15. Walter Kaufmann. Nietzsche: Philosopher, Psychologist, Antichrist. Princeton University Press, Fourth edition. 1974. Princeton. New Jersey. USA.

ABSTRACT

What does “God is dead” mean by Friedrich Nietzsche? Nietzsche spoke allegorically in his writing “Thus spoke Zarathustra” one of the Jesus’s disciple, Judas who betrayed Jesus killed the God. He also said, “Mankind ought to leave their old values and Gods they believe” through his doctrine of superman. God is an assumption for Nietzsche. Every nation and people has their own gods, idols, and values. People always have needs to worship someone or something. Thus, they urge to have a religion even after their gods’ death. Nietzsche expresses that scientific research and methodology, critical thinking and technological development make mankind equal to God. Nietzsche’s understanding of god is dead has to be understood separate from the usage of stereotype level.